



## ЗӨВЛӨМЖ

### #1. ЗӨВЛӨМЖ

**Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 1/3753 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин илэрч байгаад дүгнэлт хийх, зөвлөмжийг нэгмөр хэрэгжүүлж ажиллах.**

**Нэг.** Хөвсгөл аймаг нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-т "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана", 3.1-т "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, Сангийн хөрөнгийн зарцуулалтын байдалтай танилцахад шагналд 10.982.900 төгрөг, буцалтгүй тусламжид 37.821.000 төгрөг, олон нийтийг хамарсан арга хэмжээнд 35.976.941 төгрөг, урлаг, соёлын арга хэмжээнд 25.339.300 төгрөг гэх мэтээр зарцуулжээ. Нөөц хөрөнгийг зарцуулахдаа бусад орон аймагтай харьцуулахад Зөвлөлийн хурлаар асуудлыг хэлэлцэж хэвшсэн гэх боловч 2018 оны Зөвлөлийн хурлын 22 удаагийн тэмдэглэлтэй танилцахад иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хэлбэрийн төдий дурдсан, тухайн асуудлыг огт хэлэлцдэггүй, зөвхөн хурлын тэмдэглэлд тусгасан байна.

**Хоёр.** Иргэдээс ирүүлсэн 28 өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1д "өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ" гэж заасныг зөрчсөн. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, түүнд судалгаа, шинжилгээ хийх, хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэх зэрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, тус хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн бүртгэл хөтлөх, цохогдсон ажилтанд хүлээлгэн өгөх, шийдвэрлэлтийн хаалт хийх зэрэг бичиг хэрэг, операторын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Жишээлбэл, 2018 оны 05 дугаар сард иргэн н.Долгор, н.Энхцэцэг, н.Цолмонгэрэл, мөн нэрээ нууцлахыг хүсэн иргэдээс "2 дугаар сургууль, Гурван-Эрдэнэ сургууль, 1 дүгээр цэцэрлэгийн багш, холбогдох албан тушаалтнууд хүүхдүүдийн эцэг, эхээс хандив авч байгаа" гэх асуудлыг шалгуулахаар гомдол ирүүлснийг Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн П.Галсандорж хүлээн авч, шалгаж шийдвэрлэлгүйгээр тухайн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, захирал нарт зөрчлийг арилга гэсэн чиглэлийг өгч хаасан нь гомдол гаргагч сургууль, цэцэрлэгийн багш нарын хооронд үл ойлгогдох нөхцөл байдал үүсгэж, иргэд цаашид шат дараалан дээд шатны байгууллагад гомдол гаргах шалтгаан бий болгосон төдийгүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-т заасан "олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц" нөхцөл байдлыг үүсгэсэн байна.



2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/121 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын хагас жилийн тайлан сонсох үйл ажиллагааг зохион байгуулахад 1.014.144 төгрөг зарцуулж үргүй зардал гаргасан.

2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/496 дугаар захирамжаар LED дэлгэц түрээслэхэд 14.200.000 төгрөгийг зарцуулсан байх бөгөөд 07 дугаар сарын 03-ны өдрөөс 13-ны өдрийг хүртэлх хугацаанд гадаа талбайд хөлбөмбөгийн тэмцээн үзүүлэх зорилгоор дээрх хөрөнгийг гаргажээ.

2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/85 дугаар тушаалаар аймгийн Засаг дарга Л.Ганболд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Отгонбаяр, мэргэжилтэн Б.Батбаяр, хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Чулуунцэцэг, жолооч Э.Мөнхбат нарын 5 хүнийг Орхон аймгийн Гранд Мед эмнэлэгт нарийвчилсан үзлэг оношилгоо хийлгэхэд төсвийн хөрөнгөөс 6.221.200 төгрөг зарцуулсан байна.

## #2. ЗӨВЛӨМЖ

**Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, үргүй зардал гаргах явдлыг таслан зогсоох**



### #3. ЗӨВЛӨМЖ

***Орон нутагт  
томилолтоор ажиллаж  
буй төрийн албан  
хаагчдын албан зам  
хоног, байрны зардлыг  
Сангийн сайдын  
тушаалаар баталсан  
хэмжээгээр тухайн  
байгууллагаас  
олгосоор байхад  
тэдний байр, хоолны  
зардлыг орон нутгийн  
төсвийн хөрөнгөөс  
давхар гаргаж төсвийн  
хөрөнгийг үр ашиггүй  
зарцуулах явдлыг  
таслан зогсоох***

Монгол Улсын Шадар сайд, УИХ-ын дэд дарга, мөн яамны албан хаагчид 2018 оны 05 дугаар сарын 12-13-ны өдөр Хөвсгөл аймагт ажилласантай холбоотойгоор 2.997.100 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс /хоолонд 1.917.100 төгрөг, буудалд 1.080.000 төгрөг/ зарцуулсан.



Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 94 төсөл, арга хэмжээний баримт, материалтай танилцахад дараахв зөрчил дутагдал илэрсэн. Тухайлбал.

- "Оюунлаг Хөвсгөл" дэд хөтөлбөрийн хүрээнд 49.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээ байхгүй.

- Мөрөн сумын ЗДТГ-т автомашин нийлүүлэх 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Чингүнжавын талбайн индэрийг засварлах 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, "Хамтын оролцоо-хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 43.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, аймгийн нэгдсэн эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын өрөөг засварлах ажил худалдан авах 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх арга хэмжээ аваагүй байна.

- Төрийн албан хаагчдын тоног төхөөрөмжийг шинэчлэх 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний тухайд шалгарсан компанитай гэрээ байгуулах тухай баримт байхгүй, тоног төхөөрөмжийг 07 дугаар сарын 06-ны өдрийн дотор нийлүүлэх байтал гэрээнд заасан заалтыг зөрчин 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл, 102 хоногоор сунгасан байна.

- "Эрчим-2" амралт, сувиллын газарт шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авах 28.5 сая төгрөг, аймгийн нэгдсэн эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын өрөөг засварлах ажил, ахмадын амралт, сувиллын газрын барилгын өргөтгөл барих 800 сая төгрөгийн өртөгтэй ажлуудыг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах тухай албан ёсны зөвлөмжийг ЗДТГ-ын даргад хүргэгдээгүй байхад шалгарсан компаниудад гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлсэн байна. Тодруулбал, 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Орон нутгийн өмчийн газраас ЗДТГ-т зөвлөмж хүргүүлсэн байхад 2018 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Засаг дарга "Морин сувд" ХХК-тай гэрээ байгуулсан.

- "Оюунлаг Хөвсгөл" дэд хөтөлбөрийн хүрээнд 49.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн үнэлгээний хорооны 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэлд Багц-3-т "Икосаэдр" ХХК 46.3 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн гэж тэмдэглэсэн, харин 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийн дүгнэлтэд Багц 3-т "Икосаэдр" ХХК 7.9 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн тул шалгарсан гэж тусгасан нь тендерийг нэр төдий зохиомлоор байгуулсан гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

- Мөрөн сумын ЗДТГ-т 45.0 сая төгрөгийн автомашин нийлүүлэх "Даян дээрх эко" ХХК, 15.0 сая төгрөгийн Ёслол хүндэтгэлийн гэр нийлүүлэх "Денсфорист" ХХК, "Хамтын оролцоо-хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн хүрээнд 43.0 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх "Интерпресс" ХХК-уудын баримт материал байхгүй, шалгуур, шаардлага хангасан эсэхийг нягтлах боломжгүй.

- Ренчинлхүмбэ сумын Сантын давааны 0,6 км хайрган хучилттай авто замыг барилгын ажил худалдан авах 139.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн материалд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг баталгаажуулаагүй, зөвлөмж хүргүүлсэн баримт дутуу, гэрээ байгуулах мэдэгдэл дутуу, шалгарсан болон шалгараагүй үндэслэл дээр "Тэнгэр хишиг" ХХК-ийн үнийн санал 74.9 сая төгрөг байхад ирүүлсэн үнийн санал 121.4 сая төгрөг байна.

#### #4. ЗӨВЛӨМЖ

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг буруу хэрэглэх, тендерийг нэр төдий зохион байгуулах, ашиг сонирхлын илт зөрчилтэй компанийг сонгон шалгаруулж байгаад дүгнэлт хийх, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх**



## #5. ЗӨВЛӨМЖ

**Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил, үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд зорилтот бүлгийн эрэлт, хэрэгцээг хангахуйц байдлаар зохион байгуулах**

Аймгийн Төрийн аудитаас нийцлийн аудитын шалгалт явуулан, 2013-2015 онд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжсэн 1,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээ иргэдэд үр өгөөж өгөөгүй, үр дүнгүй байгаа талаар аймгийн Засаг даргын нэр дээр зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлтийг хангаагүй байна.



2018 оны байдлаар зээлийн хүүгийн орлого төлөвлөгөөгөөр 384.2 сая төгрөг, харин гүйцэтгэлээр 126.3 сая төгрөг төвлөрүүлсэн дүнтэй байна. Аймгийн хэмжээнд Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах зорилгоор хугацаа хэтэрсэн зээлийг 2017 онд 70 хувь, 2018 онд 70 хувьд хүргэж барагдуулах зорилт тавьсан боловч хангагдаагүй байна.

Түнэл сумын орон тооны бус зөвлөл 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй хуралдаж, “Талх, нарийн боов үйлдвэрлэх төсөл” ирүүлсэн сумын иргэн Б.Отгонбаярын төслийг дэмжин, 15.000.000 төгрөгийн зээл олгосон. Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхтэй газар дээр нь АТГ-ын ажлын хэсэг, Түнэл сумын Засаг дарга, холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын хамт очиж шалгахад зээлийг зориулалтын бусаар зарцуулсан нь тогтоогдсон болно.

## #6. ЗӨВЛӨМЖ

**Сум хөгжүүлэх сангийн зээлийн чанар, үр өгөөжийг сайжруулахад анхаарч ажиллахгүй, сумдын сангийн зээлийн эргэн төлөлт, эрсдлийг бууруулах чиглэлээр дотоод болон гадаад хяналтыг сайжруулах, албан хаагчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.**



## #7. ЗӨВЛӨМЖ

**Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.**

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн.

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай.

<https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх).